

УСНЫ КОМПАКТ

Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцтай танилцлаа



2025 оны 8 дугаар сарын 9

88.67%

УЛААНБААТАР ХОТЫН
НИЙТ УС ХАНГАМЖИЙГ
НЭМЭГДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР



93%

ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН
БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ
ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

88%

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН
БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

85%

ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН
ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ТӨСӨЛ

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх асуудлаар аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд мэдээлэл өглөө



Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газраас "Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн нөхцөл байдал, шинэ цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалт" сэдэвт уулзалт хэлэлцүүлгийг "Хангарди" ордонд 2025 оны 8 дугаар сарын 19-ний өдөр зохион

байгууллаа. Уулзалтад Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар, УСУГ-ын дарга Ц.Төрхүү, Монголын Мянганы сорилтын сан (Монголын МСС)-ийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл болон 70 гаруй үйлдвэр, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцов.

Үргэлжлэл 3-р нүүрт



ТӨСӨЛ 1. УС ХАНГАМЖИЙН БАРУУН ЭХ ҮҮСВЭРИЙГ ШИНЭЭР БАЙГУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд Биокомбинат, Шувуун фабрик орчмын газрын доорх усны ордыг түшиглэн ундны усны хоёр шинэ эх үүсвэр, ус дамжуулах шугам хоолой, дэвшилтэт технологи бүхий Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийг байгуулна. Төсөл хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамж жилд 50 сая орчим шоо метрээр нэмэгдэх юм.

Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчид Ус гүн цэвэршүүлэх үйлдвэртэй танилцлаа




2025 оны 8 дугаар сарын 8



2025 оны 8 дугаар сарын 27

АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Ричард Буанганы урилгаар Монгол Улсад суугаа гадаадын улс орнуудын Элчин сайд нар болон Олон улсын

байгууллагын төлөөлөгчид Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалттай 2025 оны 8 дугаар сарын 8 болон 27-ны өдөр танилцлаа.



“Баран групп” хүйтний улиралтай уралдан амжуулахаар ажлаа эрчимжүүлж байна. Одоогийн байдлаар 600 орчим метр шугам хоолой тавих ажил үлдээд байгаа бөгөөд Туул гол доогуур тавих хамгийн урт буюу 254 м хос шугамын өрөмдлөгийн ажил дуусах дөхөж байна.



Шувуун фабрикийн эх үүсвэрийн талбайд Туул гол доогуур нээлттэй аргаар хийсэн өрөмдлөгийн ажил дуусаж, хаалт арматураа угсарч бна. Хоёр дахь өрөмдлөгийн ажлыг майкротуннелингийн аргаар хийх юм.



Төмөр зам доогуур хийх сүвлэгээний ажилд шаардлагатай нэмэлт тоног төхөөрөмжийг оруулж ирж, бэлтгэл ажлаа хангаад дууссан. 9 дүгээр сарын эхний 7 хоногт өрөмдлөгийн ажлаа эхлэх төлөвлөлттэй байна.



10 кВ-ын шугамын ажил үргэлжилж байна. Батлагдсан нэмэлт зураг төслийн дагуу “Баран групп” 10 кВ-ын нэмэлт ажил гүйцэтгэхээр дотоодын туслан гүйцэтгэчийг шалгаруулжээ.



Цэвэршүүлсэн усны шугамыг Улаанбаатар хотын төвлөрсөн системд холболоо

Ус сувгийн төвлөрсөн шугамд цэвэршүүлсэн усны шугамыг холбох ажлыг 8 дугаар сард хийж дуусгав. Одоогоор тухайн орчныг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэж байна. Ингэснээр Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн цэвэршүүлсэн усны шугамыг Улаанбаатар хотын төвлөрсөн системд бүрэн холбоод байгаа юм.

Үйлдвэрийн ажилтнууд ус хүлээн авах бэлтгэлээ хангаж байна

УСУГ-ын 23 инженер, техникийн ажилтан шинэ ажилдаа ороод, тоног төхөөрөмжийн цэвэрлэгээ, үйлчилгээгээ хийн, турк ажилтнуудаас суралцаж, өдөр тутмын бэлтгэлийн ажлаа хийж байна. Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр усаа аваад эхэлмэгц технологийн ажилдаа орно.

Ус гүн цэвэршүүлэх үйлдвэрт 9 дүгээр сарын 30 гэхэд ус авч эхлэх урьдчилсан төлөвлөгөөтэй байгаа юм.

ТӨСӨЛ 2. ХАЯГДАЛ УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ

Төслийн хүрээнд шинэ Төв цэвэрлэх байгууламжийн дэргэд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэр ("ХУДБҮ") болон дахин боловсруулсан усыг "ДЦС-3", "ДЦС-4" ТӨХК-ууд руу дамжуулах системийг барьж байгуулна. Төсөл хэрэгжсэнээр дулааны цахилгаан станцуудын техникийн усны хэрэглээний 85 хүртэл хувийг дахин боловсруулсан усаар орлуулж, гүний цэвэр усны хэрэглээг жилд 18.0 сая хүртэл шоо метрээр бууруулах юм.

Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 93.21%



100%	Хаягдал ус хүлээн авах худгийн барилга
98%	Шахуургын станц №1
92%	Тогтворжуулах сан
95.3%	Хөдөлгөөнт био реакторын байгууламж
95%	Ламелла тунгаагуурын байгууламж
86.8%	Ширхэгт дүүргэгчтэй шүүлтүүрийн барилга
95.2%	Халдваргүйжүүлэх сан
87.3%	Шахуургын станц №2
83.7%	Ус зайлуулах сангийн барилга
82.8%	Хлор бэлтгэлийн барилга

Үйлдвэрийн зам
талбай, гадна
тохижилтын ажил
үргэлжилж байна.

Үйлдвэрт ус хүлээн авч,
урьдчилсан туршилт
тохируулгын ажлыг эхлүүлэх,
тоног төхөөрөмжийн
шалгалт, бэлтгэл ажлыг
ханган ажиллаж байна.

Инженер техникийн
ажилтнуудад зориулсан
ашиглалтын зааврыг
боловсруулж дуусаад
байна.

Дахин боловсруулсан ус дамжуулах систем, ДЦС- уудын өөрчлөлтийн ажлын явц 82.8%-тай байна



- Өргөлтийн насос станцаас "ДЦС-3" ТӨХК хүртэлх 500м голчтой 2 км шугам хоолойг угсарч суурилуулсан бөгөөд гүйцэтгэл 96.9%-тай байна.
- Салаалах худгаас өргөлтийн насос станц хүртэлх 700мм голчтой шугам хоолойн ажлын гүйцэтгэл 82%-тай үргэлжилж байна.
- "ДЦС-3" ТӨХК-ийн өөрчлөлтийн ажлын гүйцэтгэл 89% байгаа бөгөөд ус дамжуулах системийн хяналтын СКАДА системийн суурилуулалтын ажил үргэлжилж байна.

Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх асуудлаар аж ахуйн нэгжүүдийн төлөөлөлд мэдээлэл өглөө

Түрүүч нь 1-р нүүрт

Уулзалтын үеэр Монголын Мянганы сорилтын сангийн Гүйцэтгэх захирал Э.Энхгэрэл "Нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр-Аж үйлдвэрийн хаягдал устай холбоотой эрсдэлүүд" сэдвээр танилцуулга хийв. Тэрбээр "Төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх ус, Төв цэвэрлэх байгууламжаас гарах ус, ХУДБҮ-ээс ДЦС-ууд руу нийлүүлэх ус дор бүрнээ стандартын шаардлага хангаж байж аль аль нь эрсдэлгүй, аюулгүй ажиллах нөхцөл бүрдэнэ. Иймээс ТЦБ-д хүлээж авч байгаа усыг стандартын шаардлага хангуулахын тулд үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх шаардлагатай байгаа юм. Эцсийн дүндээ, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд хаягдал усаа урьдчилан цэвэрлэдэг болох нь Улаанбаатар хотыг ундалдаг, ундны эх үүсвэрийг тэтгэдэг Туул голоо эрүүл, экологийн хувьд цэвэр ариун байлгахад чухал ач холбогдолтой" гэдгийг тодотголоо.

УСУГ-ын дарга Ц.Төрхүү Төв цэвэрлэх байгууламжийн өнөөгийн байдал, шинэ Төв цэвэрлэх байгууламжийн талаар танилцуулж, Улаанбаатар хотын бохир



усны шугам сүлжээнд нийлүүлж буй хаягдал усны бохирдлын агууламжийг бууруулахад анхаарал хандуулах шаардлагатай байгааг онцлов.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар энэ үеэр бохирдуулагч үйлдвэрүүдийг бүртгэлжүүлэх, урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох, стандартын шаардлага мөрдүүлэх ажлуудыг зохион байгуулахыг үүрэг болголоо. Мөн ус бохирдуулдаггүй, урьдчилсан цэвэрлэх байгууламжтай аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллахаа илэрхийллээ.



ТӨСӨЛ 3. УСНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨСӨЛ

Усны салбарын хууль эрх зүйн орчин, бодлого зохицуулалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, салбар байгууллагуудын чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн 5 дэд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг автоматжуулах төслийг хэрэгжүүлж дууслаа



Улаанбаатар хотын 6 дүүргийн 61 хороонд байрлах 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулж, шинэчлэх төсөл 2023 оны 1 дүгээр сараас 2025 оны 8 дугаар сар хүртэл амжилттай хэрэгжиж дууслаа.


Төслийн гүйцэтгэгчээр үндэсний “Эйч Ти Эл” ХХК ажиллаж, ус түгээх байруудад автоматжуулалт, цахилгаан, узелийн шинэчлэл болон өнгөлгөөний заслын ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ УСУГ-аас өмнө нь автоматжуулсан 151 ухаалаг ус түгээх байрыг шинээр автоматжуулсан

180 ус түгээх байртай нэгтгэн хянах удирдлагын системийн программ хангамжийг хөгжүүлж, нэвтрүүлээ.

Уг төслийг хэрэгжүүлж дуусгахад УСУГ-ын Үйл ажиллагаа, техник ашиглалтын хэлтсийн дарга Д.Мөнхзулаар ахлуулсан инженер, техникийн ажилтнууд мэргэжлийн өндөр дэмжлэг үзүүлэн ажилласныг онцлон тэмдэглэж байна

Төслийн хөрөнгийг 2025 оны 9 дүгээр сард УСУГ-т хүлээлгэн өгч, хаалтын ёслолыг зохион байгуулна.

Улаанбаатар хотын унд, ахуйн уснаас сорьц цуглуулах ажил явагдаж байна



Монгол Улсын ШУА-ийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн Улаанбаатар хотын унд ахуйн усан дахь зэвийг арилгах урт хугацааны төлөвлөгөө, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна.

Тус зөвлөх үйлчилгээний хүрээнд Нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрээс эцсийн хэрэглэгч хүртэл үе шат бүрт усны сорьц цуглуулж, дүн шинжилгээ хийх бөгөөд тус ажлын эхний үе шатыг эхлүүлээд байна.

Ус хангамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, шийдвэрийг нотолгоонд тулгуурлан гаргахад уг судалгаа чухал ач холбогдолтой юм.

Ус хэрэглэгчийн нэгдсэн цахим систем хөгжүүлэх ажлын явц, системийг НЗДТГ-т хүлээлгэж өгөх талаар уулзалт зохион байгуулав



Монголын Мянганы сорилтын сангийн Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн захирал Л.Өнөржаргал, АНУ-ын Мянганы сорилтын корпорацийн Хүний хөгжлийн асуудал эрхэлсэн захирал Алисон Монтгомери нар НЗДТГ-ын дарга Д.Амгалан болон холбогдох албаныхантай 2025 оны 8 дугаар сарын 16-ны өдөр уулзаж, “Ус хэрэглэгчийн нэгдсэн цахим систем” хөгжүүлэх ажлын явц, ус хэрэглэгчийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх

болон системийн тогтвортой байдлыг хангах улмаар уг системийг Нийслэлд хүлээлгэн өгөх талаар санал солилцов.

“Ус хэрэглэгчийн нэгдсэн цахим систем”-ийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлыг Монголын МСС-ийн зөвлөх “Азийн сан” болон “Аствишн” ХХК гэрээний дагуу хариуцан ажиллаж буй бөгөөд төслийн гүйцэтгэл 80 хувьд хүрээд байгааг онцоллоо

Уулзалтын үеэр НЗДТГ-ын дарга Д.Амгалан уг төслийг бүх талаар дэмжин, хамтран ажиллахаа илэрхийлсэн юм.

УСУГ-ын эдийн засагчид зардлын тооцоолол, татаасын дүн шинжилгээний сургалтад хамрагдлаа

2025 оны 8 дугаар сарын эхний долоо хоногт Мянганы Сорилтын Корпорац (МСК)-ын зөвлөх, доктор Пидад Корүч Ус Сувгийн Удирдах Газар (УСУГ)-ын санхүү, эдийн засгийн мэргэжилтнүүдэд усны үйлчилгээний зардлын тооцоолол, татаасын дүн шинжилгээний аргачлалыг танилцуулж, сургалт зохион байгууллаа.

Оролцогчид уг аргачлалын дагуу

байгууллагынхаа үйл ажиллагааны тоо мэдээллийг шинжлэх дадлагыг хийж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрхэн ашиглах талаар дэлгэрэнгүй зааварчилгаа авав.

Энэхүү аргачлал бүхий тооцооллын хэрэгслээр цэвэр, бохир усны үйлчилгээний бодит өртгийг тооцох, зардлыг хэрэглэгчийн ангиллаар хуваарилах, хэрэглэгч хоорондын

хөндлөн татаасыг тодорхой харуулах боломжтой болох юм.

Ийнхүү уг сургалтаар УСУГ-ын ажилтнууд уг хэрэгслийг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах мэдлэг, ур чадвараа дээшлүүллээ. Усны үйлчилгээний зардлын хуваарилалтыг тодорхой болгох нь үйлчилгээний үнэ тарифын тогтолцооны шинэчлэлд чиглэсэн чухал алхам болох юм.



БАЙГАЛЬ ОРЧИН - НӨХӨН СЭРГЭЭЛТ

Барилга угсралтын ажлын төлөвлөлт, биелэлтийн бүхий л шатанд байгаль орчныг хамгаалахтай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын холбогдох хууль эрх зүйн орчин, Олон улсын санхүүгийн корпорацын Гүйцэтгэлийн стандартад нийцүүлэн ажилладаг.

“ХАБЭА-н шилдгүүд”-ийг тодруулав



Монголын Мянганы сорилтын сан Усны Комплектын хүрээнд хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаандаа хөдөлмөрийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд чухалчилдаг.

Аюулгүй ажиллагаа, эрүүл орчныг

бүрдүүлэхэд дүрэм журам мөрдөхөөс гадна эерэг соёлыг төлөвшүүлэх нь чухал. Тиймээс ХАБЭА-н соёлыг сайжруулах чиглэлээр олон төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тэдгээрийн нэг нь “ХАБЭА-н шилдгүүд”-ийг



тодруулдаг урамшууллын хөтөлбөр юм.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Ус гүн цэвэршүүлэх үйлдвэр барих төслийн гүйцэтгэгч “МАПА ИНШААТ” ХХК-ийн ХАБЭА-н шилдэг гүйцэтгэлтэй ажилтнуудыг тодруулж, урамшуулав.


Усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор хамгаалалтын бүсэд хашаа барьж эхэллээ



Усны эх үүсвэр орчимд онцгой хамгаалалтын болон энгийн хамгаалалтын бүс тогтоодог бөгөөд эдгээр бүсэд хүний үйл ажиллагаа, хог хаягдал, мал амьтны бэлчээрлэлтээс болж усны чанар, нөөцөд сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх шаардлага гардаг. Иймд Баруун эх үүсвэрийн нийт хоёр эх үүсвэрийг хамгаалах зорилгоор хашаа барих ажил эхлээд байна. Энэхүү ажил бүрэн дууссанаар усны эх үүсвэрийг аливаа сөрөг нөлөөнөөс хамгаалж, усны чанар, нөөцийг тогтвортой хадгалах нөхцөл бүрдэх юм.

Биокомбинатын газрын доорх усны эх үүсвэрийн хамгаалалтын хашааны гүйцэтгэл, метр

Төрөл	Нийт гүйцэтгэвэл зохих	Гүйцэтгэсэн	Дутуу
Хуурай газар	6.180.00 м	6.180.00 м	-
Голын дээгүүр	660.00 м	580.00 м	80.00 м
Нийт	6.840.00 м	6.760.00 м	80.00 м





УСНЫ КОМПАКТ ГЭРЭЛ ЗУРАГТ

